



ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ БОЛОН ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИУДЫН ТАНИЛЦУУЛГА

**Хэрэглэгчийн эрхийг хамгаалах
газрын дарга Ц.Лхагвасүрэн**

2018.10.10

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН, ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

Өрсөлдөөний тухай
хууль

Хэрэглэгчийн
эрхийг хамгаалах
тухай хууль

Зар
сурталчилгааны
тухай хууль

Монгол хэлний
тухай

Төрийн болон орон
нутгийн өмчийн
хөрөнгөөр бараа, ажил,
үйлчилгээ худалдан
авах тухай хууль

Сонгуулийн тухай
хууль

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

- ▶ 1991 онд батлагдаж, 2003 онд шинэчлэн найруулж, 2008 онд нэмэлт өөрчлөлт орсон.
- ▶ Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл. 4 зүйл.
- ▶ Хоёрдугаар бүлэг. Хэрэглэгчийн эрх. 7 зүйл.
- ▶ Гуравдугаар бүлэг. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүрэг. 4 зүйл
- ▶ Дөрөвдүгээр бүлэг. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах удирдлага, зохион байгуулалт. 3 зүйл.
- ▶ Тавдугаар бүлэг. Бусад зүйл. 1 зүйл.

Бүгд 5 бүлэг, 21 зүйл.



Хэрэглэгчийн
эрхийг
хамгаалах
тухай хууль
1991 онд
батлагдсан



2008 оны 12
дугаар сар.
ХЭХТ хуульд
нэмэлт
өөрчлөлт
орсноор
ШӨХТГ-т
харъяалагдсан



2009 оны 12
дугаар сар.
Хэрэглэгчийн
эрхийг
хамгаалах
үндэсний
хөтөлбөр



2016 оны 5
дугаар сар.
2016-2020
онд хэрэгжих
Хэрэглэгчийн
эрхийг
хамгаалах
үндэсний
хөтөлбөр
батлагдсан.

ХУУЛИЙН ЗОРИЛТ

Энэ хуулийн зорилт нь бараа, бүтээгдэхүүн /цаашид "бараа" гэх/ худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хэрэглэгч гэж хэн бэ?

3.1.1 “Хэрэглэгч” гэж бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээгээ хангахад зориулан захиалж, худалдан авч, үйлчлүүлж байгаа, эсхүл хэрэглэж байгаа хувь хүнийг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Чанар, аюулгүй байдлыг хангасан бараа хэрэглэх, ажил, үйлчилгээгээр хангуулах хэрэглэгчийн эрх

Аюулгүйн шаардлагыг хангасан бараа хэрэглэх, ажил, үйлчилгээгээр хангуулах

Удаан хэрэглэх бараанд 6 сарын хугацаанд барааны чанар, аюулгүй байдлын баталгаа авах

Гэм хор учруулсны төлбөрийг Иргэний хуулийн 18, 52 дугаар бүлэгт заасны дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлэх

Зөрчигдсөн эрхээ хэрэглэгчийн эрхийг хамгаалах ТББ-аар дамжуулан хамгаалуулах

Барааны холбогдох баримт бичиг, зөвшөөрөл, чанарын баталгаажилтын дүгнэлтийг шаардан үзэх

Барааны доголдлыг арилгуулах, хохирлоо нөхөн төлүүлэх талаар дараах шаардлагын аль нэгийг гаргах эрхтэй:

Барааны доголдлыг үнэ төлбөргүй арилгуулах буюу арилгуулахад гаргасан зардлыг нөхөн төлүүлэх;

Барааны үнийг доголдлын хэмжээтэй дүйцүүлэн бууруулах;

Гэрээнд заасан тоо, хэмжээнээс дутуу барааг хүлээн авахаас татгалзах, гэрээг цуцлах эсхүл үнийг тооцож авах;

Доголдолтой барааг тухайн төрлийн доголдолгүй бараагаар солих, эсхүл барааг буцаан өгч, үнийг тооцож авах;

Барааны талаар мэдээлэл авах хэрэглэгчийн эрх



Бараа үйлдвэрлэгчийн нэр, хаяг



Барааны нэр төрөл, хэмжээ, хэмжих нэгж, үнэ, зориулалт



Барааны хэрэглээний шинж чанар, орц, найрлага, хадгалах, хэрэглэх арга,



Барааны баталгаат болон эдэлгээний хугацаа, таних тэмдэг, код

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүрэг

Заавал мөрдөх стандартын болон техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан

Хэрэглэгчээс тавьсан шаардлагыг хуульд заасны дагуу барагдуулах, учирсан хохирлыг нөхөн төлөх

Бараа, ажил, үйлчилгээнд аюултай байдал илэрвэл энэ талаар олон нийтэд нэн даруй мэдээлнэ

Хэрэглэгчид барааны талаар худал мэдээлэл өгөхийг хориглоно

2. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүргээ хэрэгжүүлээгүй бол **ХҮНИЙГ ТАВАН ЗУУН НЭГЖТЭЙ ТЭНЦЭХ ХЭМЖЭЭНИЙ ТӨГРӨГӨӨР, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ТАВАН МЯНГАН НЭГЖТЭЙ ТЭНЦЭХ** хэмжээний төгрөгөөр торгоно.

500
МЯНГА

5 САЯ

3. Бараа, ажил, үйлчилгээг хууран мэхлэх, төөрөгдүүлэх, хүч хэрэглэх замаар худалдах, гүйцэтгэх, эсхүл хэрэглэгчийн эрхийг хохироосон гэрээ байгуулсан, эсхүл хууль, гэрээнд заасан чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан бараа хэрэглэх, ажил, үйлчилгээгээр хангуулах эрхийг зөрчсөн бол **ХҮНИЙГ ХОЁР МЯНГАН НЭГЖТЭЙ ТЭНЦЭХ ХЭМЖЭЭНИЙ ТӨГРӨГӨӨР, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ХОРИН МЯНГАН НЭГЖТЭЙ ТЭНЦЭХ ХЭМЖЭЭНИЙ ТӨГРӨГӨӨР** торгоно.

2 САЯ


20 САЯ

5. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн зах зээлд нийлүүлж байгаа бараа, ажил, үйлчилгээ нь хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулсан, эсхүл заавал мөрдөх стандартын болон техникийн зохицуулалтын шаардлагыг хангаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж **ХҮНИЙГ ЕСӨН ЗУУН НЭГЖТЭЙ ТЭНЦЭХ ХЭМЖЭЭНИЙ ТӨГРӨГӨӨР, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ЕСӨН МЯНГАН НЭГЖТЭЙ ТЭНЦЭХ ХЭМЖЭЭНИЙ ТӨГРӨГӨӨР** торгоно.

900
МЯНГА

9 САЯ

ИРГЭДЭЭС ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ЕРӨНХИЙ АГУУЛГА /2018 оны эхний хагас жил/



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН, ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

Өрсөлдөөний тухай хуулийн зорилт:

Энэ хуулийн зорилт нь аж ахуй эрхлэгчийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах, өрсөлдөөнийг зохицуулах байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 01 тогтоол

- ▶ Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 01 тоот тогтоолоор Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоосон.
- ▶ Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын харъяа хэрэглэгчдэд үйлчлэх 16 төв байдаг.
- ▶ Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний зах зээлд үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий зүй ёсны монополиор тогтоогдсон нийт 52 аж ахуй эрхлэгч байдаг.

Өрсөлдөөний тухай хууль

- ▶ **6 дугаар зүйл.Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах**
 - ▶ 6.1.Энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаанд дараахь зохицуулалт хийнэ:
 - ▶ 6.1.1.зах зээлд нийлүүлж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний тоо, хэмжээний өөрчлөлтийн талаар хүчин чадалтай нь уялдуулан хянан зохицуулах;
 - ▶ 6.1.2.бодит зардлыг нь харгалзан тухайн бараа бүтээгдэхүүнийг борлуулах үнийн өөрчлөлтийг хянан зөвшөөрөл олгох.
 - ▶ 6.2.Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгч энэ хуулийн 7.1-д заасан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
 - ▶ 6.3.Хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгож, тарифын зохицуулалт хийгддэг, зохицуулах байгууллагатай салбарт энэ хуулийн 6.1.1, 6.1.2 дахь заалт хамаарахгүй.

Зөрчлийн тухай хууль

- ▶ **Зөрчлийн тухай хуулийн 10.7 дугаар зүйл.**
- ▶ 5. Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгч бараа бүтээгдэхүүнийхээ тоо, хэмжээ, үнийн өөрчлөлтийг хуульд заасны дагуу холбогдох байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл аваагүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлого, эд зүйлийг хурааж бараа бүтээгдэхүүний өмнөх жилийн борлуулалтын орлогын 3 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- ▶ 9. Зүй ёсны монополь байдалтай, давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч өөрийн зүй ёсны монополь байдал, давамгайл байдлаа хууль бусаар ашиглаж хуулиар хориглосон ноёлох үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг бараа бүтээгдэхүүний өмнөх жилийн борлуулалтын орлогын 4 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**Анхаарал хандуулсанд
баярлалаа.**